



ЗАВСРЫН ҮЕИЙН ХУРААНГУЙ НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2019 болон 2020 оны 6-р сарын 30-ны өдрөөр дуусгавар
болсон гурван сар болон хагас жилийн тайлан

(Канад доллараар)
(Аудитаар баталгаажаагүй)

Удирдлага бэлтгэв – Уншигчдад хүргүүлэх мэдэгдэлтэй танилцана уу.

УНШИГЧДАД ХҮРГҮҮЛЭХ МЭДЭГДЭЛ

National Instrument 51-102 Мэдээллийн ил тод байдлын үүрэг хариуцлага, 4-р хэсэг, 4.3 (3) а-д заасны дагуу хэрэв завсрын үеийн хураангуй нэгтгэсэн санхүүгийн тайланг аудитор хянан, баталгаажуулаагүй тохиолдолд энэхүү мэдэгдлийг хавсаргах үүрэг хүлээдэг. Энэхүү аудитаар баталгаажуулаагүй завсрын үеийн хураангуй нэгтгэсэн тайланг Компанийн удирдлага бэлтгэсэн. Удирдлага нь Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорацийн 2019 оны 12 сарын 31 болон 2020 оны 6 сарын 30-ны байдлаар санхүүгийн тайланг нэгтгэн, 2019, 2020 оны 6 сарын 30-аар дуусгавар болсон 3 ба 6 сарын хугацааны нийт алдагдал, эздийн өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний мэдээллийг боловсруулсан. Компанийн хараат бус аудитор нь 2019, 2020 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон завсрын үеийн хураангуй нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийх, хянах болон ямарваа нэгэн байдлаар мэдээллийн үнэн зөв байдлыг баталгаажуулаагүй болно. Уншигчдын зорилготой нийцэхгүй байх магадлалтай тул энэхүү мэдэгдлийг хүргүүлэв.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй, Нэгтгэсэн Завсрын Санхүүгийн Тайлан
(Канад доллараар)

	Тодруулга	2020.06.30	2019.06.30
Хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		\$ 1,915,353	\$ 5,106,863
Дансны авлага		118,414	70,361
Урьдчилж төлсөн авлага		50,716	69,029
Эргэлтийн хөрөнгийн дүн		2,084,483	5,246,253
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	4	24,848,526	21,483,517
Хөрөнгө ашиглах эрх	5	122,379	137,064
Үндсэн хөрөнгө		99,944	105,998
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		25,070,849	21,726,579
Нийт хөрөнгийн дүн		\$ 27,155,332	\$ 26,972,832
Өр төлбөр ба эздийн өмч			
Арилжаа болон бусад өглөг		\$ 1,085,439	\$ 591,999
Түрээсийн өмч	5	26,786	25,697
Эргэлтийн өр төлбөр		1,112,225	617,696
Түрээсийн өмч	5	99,890	113,553
Хөрвөх боломжтой өр төлбөр	7	13,185,450	6,260,521
Эргэлтийн бус өр төлбөр		13,285,340	6,374,074
Өр төлбөрийн нийт дүн		14,397,565	6,991,770
Эздийн өмч			
Хувьцаат капитал	8	\$ 109,862,154	\$ 109,466,565
Нэмж төлөгдсөн капитал		16,804,518	16,829,920
Бусад хуримтлагдсан алдагдал		(1,832,123)	(1,958,616)
Алдагдал		(112,076,782)	(104,356,807)
Эздийн өмчийн дүн		12,757,767	19,981,062
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн		\$ 27,155,332	\$ 26,972,832

Гэрээгээр хүлээсэн үүрэг (Тодруулга 6)

Тайлант хугацаанд өрнөсөн үйл явдлууд (Тодруулга 13)

Дагалдах тодруулгууд нь хураангуй, нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

Төлөөлөн Удирдах Зөвлөл ("ТУЗ")-ийг төлөөлж баталсан:

Гарын үсэг зурсан "Жон П.Бюрн"

_____ ТУЗ-ийн гишүүн

Гарын үсэг зурсан "Т. Лэйтон Крофт"

_____ ТУЗ-ийн гишүүн

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураагуй, Нэгтгэсэн Завсрын Алдагдлын Дэлгэрэнгүй Тайлан
(Канад доллараар)

Тодруулга	6.30-аас дуусгавар болсон гурван сар		6.30-аас дуусгавар болсон зургаан сар		
	2020	2019	2020	2019	
Үйл ажиллагааны зардал					
Хайгуул, үнэлгээний зардал	9	\$ 134,046	\$ 246,036	\$ 311,241	\$ 423,586
Ерөнхий ба удирдлагын зардал	10	351,984	497,928	726,058	844,244
Үйл ажиллагаанаас учирсан алдагдал		486,030	743,964	1,037,299	1,267,830
Санхүүгийн орлого		(343)	(7,425)	(17,339)	(17,657)
Хүүгийн зардал		502,991	-	1,114,261	-
Санхүүгийн хэрэглээс үүдсэн үнэ цэнийн зөрүү		5,740,401	-	5,564,698	-
Гадаад валютын ханшийн зөрүүнээс гарсан гарз		(51,094)	18,752	21,056	21,805
Цэвэр алдагдал		\$ 6,677,985	\$ 755,291	\$ 7,719,975	\$ 1,271,978
Бусад дэлгэрэнгүй алдагдал (олз):					
Охин компанийн хөрвүүлгээс үүдсэн гадаад валютын ханшийн зөрүү		1,139,669	378,326	(126,493)	568,323
Бусад дэлгэрэнгүй алдагдал (олз)		1,139,669	378,326	(126,493)	568,323
Нийт дэлгэрэнгүй алдагдал		\$ 7,817,654	\$ 1,133,617	\$ 7,593,482	\$ 1,840,301
Нэгж хувьцаанд ногдох суурь алдагдал		\$ 0.03	\$ 0.01	\$ 0.04	\$ 0.01
Нийт хувьцааны жигнэсэн дундаж тоо		192,167,922	174,204,930	191,890,375	170,472,971

Дагалдах тодруулгууд нь хураангуй, нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураагуй, Нэгтгэсэн Завсрын Алдагдлын Дэлгэрэнгүй Тайлан
(Канад доллараар)

	Тодр уулга	Хувьцааны тоо ширхэг	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан бусад дэлгэрэнгүй алдагдал	Алдагдал	Нийт эздийн өмч
2019.01.01-ний үлдэгдэл		162,426,416	\$ 104,003,644	\$ 16,110,116	\$ (955,713)	\$ (101,673,515)	\$ 17,484,532
Тайлант хугацааны нийт алдагдал:							
Цэвэр алдагдал		-	-	-	-	(1,271,978)	(1,271,978)
Бусад дэлгэрэнгүй алдагдал		-	-	-	(568,323)	-	(568,323)
Хаалттай хүрээнд гаргасан хувьцааны цэвэр зардал		11,014,544	2,194,102	225,692	-	-	2,419,794
Хэрэгжүүлсэн опцион		1,105,000	276,900	(107,100)	-	-	169,800
Олгосон ирээдүйд олгогдох хувьцааны эрх		175,069	30,005	(30,005)	-	-	-
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр		-	-	377,960	-	-	377,960
Эзэмшигчидтэй хийсэн нийт хэлцэл гүйлгээ		12,294,613	2,501,007	466,547	-	-	2,967,554
2019.06.30-ний үлдэгдэл		174,721,029	\$ 106,504,651	\$ 16,576,663	\$ (1,524,036)	\$ (102,945,493)	\$ 18,611,785
2020.01.01-ний үлдэгдэл		191,068,490	\$ 109,466,565	\$ 16,829,920	\$ (1,958,616)	\$ (104,356,807)	\$ 19,981,062
Тайлант хугацааны нийт алдагдал:							
Цэвэр алдагдал		-	-	-	-	(7,719,975)	(7,719,975)
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-	-	126,493	-	126,493
Хэрэгжүүлсэн опцион	8	1,150,000	262,625	(90,125)	-	-	172,500
Олгосон ирээдүйд олгогдох хувьцааны эрх	8	719,212	132,964	(132,964)	-	-	-
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	8	-	-	197,687	-	-	197,687
Эзэмшигчидтэй хийсэн нийт хэлцэл гүйлгээ		1,869,212	395,589	(25,402)	-	-	370,187
2020.06.30-ний үлдэгдэл		192,937,702	\$ 109,862,154	\$ 16,804,518	\$ (1,832,123)	\$ (112,076,782)	\$ 12,757,767

Дагалдах тодруулгууд нь хураангуй, нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй, нэгтгэсэн завсрын мөнгөн гүйлгээний тайлан
(Канад доллараар)

Тодруулга	06.30-аар дуусгавар болсон гурван сар		06.30-аар дуусгавар болсон зургаан сар	
	2020	2019	2020	2019
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ				
Цэвэр алдагдал	\$ (6,677,985)	\$ (755,291)	(7,719,975)	\$ (1,271,978)
Мөнгөн бус гүйлгээнүүд				
Элэгдэл, хорогдол	12,945	5,764	25,969	11,277
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	133,167	325,509	197,687	377,960
Санхүүгийн орлого (гарз)	(343)	(7,425)	(17,339)	(17,657)
Капиталжуулсан хүүгийн зардал	7 500,730	-	1,109,606	-
Мөнгөн бус гадаад валют	(123,977)	18,752	(51,827)	21,805
Хөрвөх нөхцөлтэй өр төлбөрийн үнэ цэнийн өөрчлөлт	5,813,284	-	5,637,581	-
Мөнгөн бус эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт	438,243	359,843	465,871	435,182
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	96,064	(52,848)	(352,427)	(443,411)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:				
Энгийн хувьцаа гаргасан цэвэр зардал	-	-	-	2,419,794
Опцион хэрэгжүүлсний төлбөр	172,500	124,300	172,500	169,800
Түрээсийн төлбөрийн эргэн төлөлт	(6,353)	-	(12,574)	-
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	166,147	124,300	159,926	2,589,594
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:				
Хайгуул, хөрөнгийн үнэлгээний зардал	4 (1,902,456)	(1,561,424)	(3,237,191)	(2,324,957)
БЦАТ буцаан худалдан авалт	-	(1,200,000)	-	(1,200,000)
Үндсэн хөрөнгийн зардал	(1,401)	(3,323)	(4,119)	(9,593)
Хүүний орлого	343	7,425	17,339	17,657
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(1,903,514)	(2,757,322)	(3,223,971)	(3,516,893)
Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	(120,593)	(20,605)	224,962	(23,697)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн өсөлт (бууралт)	(1,761,896)	(2,706,475)	(3,191,510)	(1,394,407)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, хугацааны эхэнд	3,677,249	3,060,317	5,106,863	1,748,249
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, хугацааны эцэст	\$ 1,915,353	\$ 353,842	1,915,353	\$ 353,842

Дагалдах тодруулгууд нь хураангуй, нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй, нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулсан)

2019 болон 2020 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сар болон хагас жилийн тайлан

1. Үйл ажиллагааны тайлан:

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (“Эрдэнэ Ресурс” “Корпораци” эсвэл “Компани” гэх) нь Канад улсад төвтэй, үнэт болон суурь металлын хайгуулын үйл ажиллагааг Монгол улсад эрхэлдэг. Компанийн үнэт цаас нь Торонтогийн Хөрөнгийн Бирж дээр “ERD”, Монголын Хөрөнгийн Бирж дээр “ERDN” тикертэйгээр арилжаалагддаг. Компанийн албан хаяг нь 1300-1969 Upper Water Street, Halifax, Nova Scotia, B3J 2V1.

Эрдэнэ Ресурс нь үнэт болон суурь металлын хайгуул, хөрөнгө оруулалт болон төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагааг Монгол улсын баруун бүсэд эрхэлдэг. Компанийн голлох төсөл нь Монгол улсын Баянхонгор аймагт орших Хөндий Алтны Төсөл юм.

2020 оны 07 дугаар сард Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий Алтны Төслийн хараат бус нарийвчилсан ТЭЗҮ-ийн үр дүнг танилцуулсан. Компанийн үйл ажиллагаа үргэлжлэх, ашигт малтмалын өмчид капиталжуулсан хөрөнгийг нөхөн олох эсэх нь эдийн засгийн хувьд ашигтай нөөц, компанийн хайгуул, бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай санхүүжилтийг олох чадвар болон үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашигтай байдал эсвэл нэг буюу түүнээс дээш хөрөнгийн худалдаанаас олсон орлого зэргээс хамаарна.

2. Тайлангийн үндэслэл

2020 оны 6 дугаар сарын 30-нд дуусгавар болсон хагас жилийн хураангуй нэгтгэсэн санхүүгийн тайланг (“Завсрын үеийн санхүүгийн тайлан”) Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (“НББОУС”) 34 - завсрын санхүүгийн тайлагналын дагуу боловсруулсан. Завсрын үеийн санхүүгийн тайлан нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (“НББОУСЗ”)-ийн гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (“СТОУС”)-ын дагуу боловсруулагдсан 2019 оны 12 дугаар сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан (“Жилийн эцсийн санхүүгийн тайлан”)-тай хамтад нь танилцах шаардлагатай.

Хураангуй нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайланг тайлагнахыг 2020 оны 8 дугаар сарын 13-ны өдөр ТУЗ-өөр зөвшөөрсөн болно.

3. Улирлын шинж чанар

Монгол улс дахь цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан хайгуулын зардал, хайгуул үнэлгээний хөрөнгийн хөрөнгө оруулалтууд нь жилийн хоёр ба гуравдугаар улиралд төвлөрдөг тул компанийн үйл ажиллагаа нь улирлын шинж чанарыг агуулдаг.

4. Хайгуул, үнэлгээний хөрөнгө

	Хөндий Алтны Төсөл	Зуун Мод Улаан ба бусад	Нийт
2019.01.01 үлдэгдэл	\$ 13,930,310	\$ 1,757,038	\$ 15,687,348
Нэмэгдэл	6,735,135	68,993	6,804,128
Валютын ханшийн шилжилтийн нөлөө	(897,504)	(110,455)	(1,007,959)
2019.12.31 үлдэгдэл	\$ 19,767,941	\$ 1,715,576	\$ 21,483,517
2020.01.01 үлдэгдэл	\$ 19,767,941	\$ 1,715,576	\$ 21,483,517
Нэмэгдэл	3,184,486	52,705	3,237,191
Валютын ханшийн шилжилтийн нөлөө	114,851	12,967	127,818
2020.06.30 үлдэгдэл	\$ 23,067,278	\$ 1,781,248	\$ 24,848,526

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй, нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулсан)

2019 болон 2020 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сар болон хагас жилийн тайлан

4. Хайгуул, үнэлгээний хөрөнгө (үргэлжлэл)

Компанийн Монгол улс дахь ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг Компанийн охин компаниуд болох Эрдэнэ Монгол ХХК, Аниан Ресорзис ХХК, Лидер Эксплорэйшн ХХК эзэмшдэг. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл нь гурван жилийн хугацаанд хүчинтэй ба хугацааг 12 хүртэл жилээр сунгах боломжтой. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаанд олгодог бөгөөд 20 хүртэл жилээр 2 удаа сунгах боломжтой. Тусгай зөвшөөрлүүдийн жилийн төлбөрийг төлснөөр тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр байна.

Хөндий Алтны Төсөл

Хөндий Алтны Төсөл нь Монгол улсын Баянхонгор аймагт, Баян Хөндийн нөөцийг агуулсан 2,309 га ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай, 2,205 га Хөндий хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайг хамарч оршдог. 4,669 га Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд Алтан Нар алт, мөнгө, хар тугалга, цайрын орд оршдог. 2018 оны 9 дүгээр сарын 30-ийг хүртэл Хөндий болон Алтан Нар тусгай зөвшөөрлийн Хайгуул, үнэлгээний зардлыг тусад нь мэдээлдэг байв.

2019 оны 8 сарын 5-нд Монгол улсын Ашигт Малтмал, Газрын Тосны Газар (“АМГТГ”) нь Хөндий хайгуулын тусгай зөвшөөрлийн нэг хэсгийг хөрвүүлэх замаар Баян Хөндийн нөөцөд ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгосон. Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрөл нь Tetra Tech Inc-ийн боловсруулж, 2018 оны 12 сарын 4-нд танилцуулсан “Khundii Gold Project, NI 43-101 Technical Report” нэртэй тайлан дахь Баян Хөндийн геологийн ба үйлдвэрлэлийн нөөцийг багтаасан. Түүнээс гадна ашиглалтын тусгай зөвшөөрөлд Эрдэнэ Ресурсийн Хар Морь, Хойд Хөндий, Баруун Хөндий зэрэг хэтийн төлөв бүхий талбай багтаж байна.

Хөндий тусгай зөвшөөрлийн талбайгаас 2,205 га талбай нь ашиглалтын тусгай зөвшөөрөлд шилжээгүй, хайгуулын тусгай зөвшөөрөл хэвээр байна. Энэхүү хайгуулын тусгай зөвшөөрөл нь 12 жилийн 10 дахь жилдээ хүчинтэй байгаа бөгөөд 12 жилийн хугацаа дуусахаас өмнө Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулийн дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл болгох боломжтой.

Компани нь 2016 оны 7 сарын 1-ээс капиталжуулах бодлогын дагуу хайгуулын зардлыг капиталжуулж эхэлсэн. Үүнээс өмнө зөвхөн Баян Хөндий тусгай зөвшөөрлийн төлбөрийг капиталжуулж байсан.

2020 оны 3 сарын 5-нд Ашигт Малтмал Газрын Тосны Газар Цэнхэр Номин хайгуулын тусгай зөвшөөрлийг Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрөл болгон бүртгэсэн. 2015 оны 1 сарын 1-нд Алтан Нарын анхан шатны нөөцийн тооцооллыг гүйцэтгэсэн бөгөөд Компани нь капиталын бодлогын дагуу хайгуулын зардлыг капиталжуулж эхэлсэн. Компани нь 2015 оноос өмнө зөвхөн Алтан Нартай холбоотой тусгай зөвшөөрлийн төлбөрийг капиталжуулж байсан.

Зуун Мод, Улаан болон Бусад

Зуун Мод төсөл нь Монгол улсын Баянхонгор аймагт байрладаг. 6,041 га талбайг хамарсан тусгай зөвшөөрлийн талбайд молибден-зэсийн нөөц бүхий орд оршдог. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2011 онд олгосон. Молибденийн зах зээлийн үнэ нэмэгдэх үед Зуун Мод зэс-молибденийн төслийг хөгжүүлэх боломжтой бөгөөд Компани нь технологи ба зах зээлийн хүчин зүйлсийг магадлан судална.

Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай нь Хөндий тусгай зөвшөөрлийн талбайтай хил залгаа, нийт 1,780 га талбайг хамардаг. Хайгуулын тусгай зөвшөөрөл нь 12 жилийн 4 дэх жилдээ хүчин төгөлдөр байгаа бөгөөд Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулийн дагуу цаашид 12 жилийн хугацаа дуусахаас өмнө ашиглалтын тусгай зөвшөөрөлд шилжүүлэх боломжтой. 2017 оны 8 сарын 30-нд Эрдэнэ Ресурс нь Лидер Эксплорэйшн ХХК (Монгол улсын)-ийн 51%-ийг худалдаж авсан. Эрдэнэ Ресурс нь СТОУС 3-ийн дагуу үнэлгээ гаргасан бөгөөд үнэлгээгээр энэхүү гэрээ хэлцэл нь хөрөнгө худалдан авах ангилалд багтана (бизнес худалдан авах бус) гэсэн дүгнэлтэд хүрсэн.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй, нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулаагүй)

2019 болон 2020 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сар болон хагас жилийн тайлан

4. Хайгуул, үнэлгээний хөрөнгө (үргэлжлэл)

Эрдэнэ Ресурс нь 2020 оны 8 дугаар сарын 30 хүртэл \$600,000 ам.долларын хайгуулын ажил гүйцэтгэснээр Лидер Эксплорэйшн ХХК-ийн үлдсэн 49%-ийг зах зээлийн үнэлгээгээр худалдан авах эрх үүснэ. 2020 оны 6 сарын 30-ны байдлаар хайгуулын ажлыг гүйцэтгэх нөхцөлийг биелүүлснээр үлдсэн хувьцааг авах эрх үүссэн. Компани нь жилд багадаа \$100,000 ам.долларын хайгуул судалгаанд зарцуулснаар дээрх эрхийг сунгах боломжтой.

5. Түрээс

Компани нь 2019 оны 9 сарын 1-ээс эхлэн 5 жилийн оффисын түрээсийн гэрээ хийсэн. Энэхүү түрээс нь баланс дээр түрээсийн өр төлбөр, хөрөнгө ашиглах эрх болон танилцуулсан. Түрээсийн хөнгөлөлт 7%-аар тооцсон.

Хөрөнгө ашиглах эрхийн талаар нэмэлт мэдээлэл:

2019.01.01 үлдэгдэл	\$	-
Нэмэгдэл		146,854
Элэгдэл		(9,790)
2019.12.31 үлдэгдэл	\$	137,064
2020.01.01 үлдэгдэл	\$	137,064
Нэмэгдэл		-
Элэгдэл		(14,685)
2020.06.30 үлдэгдэл	\$	122,379

2020 оны 6 сарын 30-ний байдлаар төв оффисын түрээсийн өр төлбөрийн хугацаа дуусах тухай:

	1 жилийн дотор	1-2 жил	2-3 жил	3-4 жил	Нийт
Түрээсийн төлбөр	\$ 34,511	\$ 34,522	\$ 34,951	\$ 40,876	\$ 144,860
Санхүүгийн зардлууд	(7,725)	(5,612)	(3,489)	(1,358)	(18,184)
Нийт төлбөр	\$ 26,786	\$ 28,910	\$ 31,462	\$ 39,518	\$ 126,676

Компанийн Монгол улс дахь оффис болон ажилтнуудын байрны түрээс нь 12 сарын дотор хугацаа дуусна. Компани нь СТОУС 16-ын шаардлагыг эдгээр төлбөрт тусгахгүй байхаар шийдсэн бөгөөд түрээсийн төлбөрийг зарлагасанаар бүртгэсэн.

6. Гэрээгээр хүлээсэн үүрэг

2020 онд Алтан Нар, Хөндий тусгай зөвшөөрлийн талбайд хайгуулын зардалд хамгийн багадаа \$10/га ам.долларыг зарцуулах нөхцөлтэй (тус бүр \$46,690, \$22,050 ам.доллар). Эрдэнэ Ресурс нь гурван жилийн хугацаанд \$600,000 ам.долларын хайгуулын ажил гүйцэтгэх нөхцөлийг биелүүлснээр, 2020 оны 06 сарын 30-ны байдлаар Лидер Эксплорэйшн ХХК-ийн үлдсэн 49%-ийг зах зээлийн үнээр худалдан авах эрх үүснэ. Жилд \$100,000 ам.долларын хайгуулын ажлыг гүйцэтгэснээр 49%-ийг худалдан авах хугацааг сунгах боломжтой. (Тодруулга 4-өөс харна уу.)

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй, нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулаагүй)

2019 болон 2020 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сар болон хагас жилийн тайлан

6. Гэрээгээр хүлээсэн үүрэг (үргэлжлэл)

Компани нь Алтан Нар ба Хөндий тусгай зөвшөөрлийн хүрээнд 1%-ийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөр ("NSR")-ийг Сэндсормд төлөх үүрэг хүлээсэн. Сэндсорм нь Алтан Нар болон Хөндий тусгай зөвшөөрлийн хувьд ирээдүйн роялти ба стрийм санхүүжилттэй холбоотой давуу эрх эдлэх нөхцөлтэй.

Галлант Минерал Лимитед нь Зуун Мод ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд 1.5%-ийн NSR хүлээн авах эрхтэй. Энэхүү гэрээний хүрээнд Компани нь Зуун Мод ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хайгуулын ажил гүйцэтгэх үүрэг хүлээгээгүй.

2020 оны 3 сарын 31-нд Компани нь нийт \$250,000 ам.долларын үнийн дүнтэй Хугацаат Зээлийн Гэрээ ("Зээлийн гэрээ") байгуулсан. Зээлийн гэрээ нь Компанид шаардлагатай тохиолдолд 2023 оны 3 сарын 31-ний өдөр эсвэл Компани нь өөр санхүүжилт авах хүртэл хүчинтэй байна. Зээлийн гэрээний үндсэн төлбөрийн хүү нь жилийн 10%. Зээлийн гэрээ нь баталгаагүй бөгөөд Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкаас авсан зээлд харьяалагдана.

7. Хөрвөх нөхцөлтэй зээлийн тухай

2019 оны 10 сарын 11-нд Эрдэнэ Ресурс нь Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк ("EBRD")-аас 5 сая ам.доллар (6.6 сая кан.доллар)-ын хөрвөх нөхцөлтэй зээл авсан. Анхны санхүүжилтийг 2.5 сая ам.долларын гүйлгээ 2019 оны 11 сарын 4-нд, хоёр дахь санхүүжилт болон 2.5 сая ам.долларын гүйлгээ 2019 оны 11 сарын 25-нд хийгдсэн.

Хөрвөх зээлийн үндсэн нөхцөлүүд:

- Эрдэнэ Ресурсийн сонголтоор жил тутамд бэлэн мөнгө эсвэл өөр хэлбэрээр төлөх 10%-ийн хүү
- 2022 оны 10 сард хугацаа дуусна
- Нэг, хоёр, гурван жилийн хугацаанд нэгж хувьцааг \$0.20 канад доллараар үнэлж, жил тус бүр 10%, 20%, 30%-ийн нэмэгдэл үнэлгээтэйгээр EBRD-ийн сонголтоор хэсэгчлэн болон бүтнээр компанийн Энгийн хувьцаанд хөрвүүлэх боломжтой.
- Хөрвөх үнэ нь нэг, хоёр, гурван жилийн хугацаанд 10%, 20%, 30%-ийн нэмэгдэл үнэлгээтэйгээр хөрвөх өдрөөс өмнө 5 өдрийн жигнэсэн дундаж ханш байна.
- Зээлийг дараах хоёр нөхцөлийн аль нэг нь бүрдсэний дараа 25%-ийн нэмэгдэлтэйгээр эргүүлэн төлж болно, үүнд: (1) NI 43-101 стандартын дагуу хийгдсэн нарийвчилсан ТЭЗҮ-ийг бүртгүүлэх эсвэл Эрдэнэ Ресурсийн хяналтын багц солигдох (2) анхны санхүүжилтийн гүйлгээ хийгдсэнээс хойш 24 сар өнгөрсөн тохиолдолд.

Компанийн төслүүдийг эзэмшдэг Эрдэнэ Ресурсийн Монгол дахь охин компанийн хувьцаа нь зээлийн баталгаа болно.

Нягтлан бодох бүртгэлийн зорилгоор Зээл нь холимог санхүүгийн хэрэглүүрт орох ба үүнд: зээлийн үндсэн үүрэг, хөрвүүлэлт ба урьдчилгаа төлбөрийн шинж чанаруудыг багтаасан үүсмэл санхүүгийн хэрэгслүүд орно. Компани нь зээлийн үүргийг зээлийн хугацааны эцэс хүртэл хуримтлагдсан өртгөөр тооцно. Хөрвүүлэлт ба урьдчилгаа төлбөрийн опционыг ашиг эсвэл алдагдлын бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн өр төлбөр болгон тооцно.

Зээл олгосон өдөр буюу 2019 оны 11 сард, зээлийн бүрэлдэхүүн хэсгүүдийг бодит үнэ цэнээр үнэлснийг доорх хүснэгтэд харуулав:

Олгосон өдрийн өр төлбөрийн бүрэлдэхүүн	\$	4,505,902
Олгосон өдрийн хөрвүүлэлт, урьдчилан төлөх опцион		2,106,123
Санхүүгийн зардал		(254,262)
Цэвэр орлого	\$	6,357,763

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй, нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулаагүй)

2019 болон 2020 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сар болон хагас жилийн тайлан

7. Хөрвөх нөхцөлтэй зээлийн тухай (үргэлжлэл)

Өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсэгт орсон өөрчлөлт:

	6 сарын 30 2020	12 сарын 31 2019
Дансны үнэ, хугацааны эхэнд	\$ 4,333,370	\$ 4,251,640
Капиталжуулсан хүүгийн зардал	1,109,606	162,051
Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	177,742	(80,321)
Хаалтын үлдэгдэл	\$ 5,620,718	\$ 4,333,370

Хөрвөх опционыг бодит үнэ цэнээр бүртгэсэн ба 2020.06.30-ы байдлаар үнэ цэнийг биномын опционы үнэлгээний загварт тулгуурлан, дараах үндсэн төсөөллүүдийг ашиглан тодорхойлсон. Үүнд: 82%-ийн хэлбэлзэл, 0.3% эрсдэлгүй хүүгийн хэмжээ, 2.3 жилийн хөрвөх опционы хугацаа багтсан.

Опционы хөрвүүлэлтийн бүрэлдэхүүн хэсэгт орсон өөрчлөлт:

	6 сарын 30 2020	12 сарын 31 2019
Опционы хөрвүүлэлт, хугацааны эхэнд	\$ 1,927,151	\$ 2,106,123
Бодит үнэ цэнийн тохируулга	5,637,581	(178,972)
Хаалтын үлдэгдэл	\$ 7,564,732	\$ 1,927,151

8. Хувьцаат капитал, нэмэлт хөрөнгө

Хувьцаа гаргах бүрэн эрх

Нэрлэсэн үнэгүй, хязгааргүй энгийн хувьцаа гаргах эрхтэй.

Гаргасан хувьцаа

Ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн хөтөлбөрийг Компани 2013 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, албан тушаалтнуудыг урамшуулах хувьцааны опционы төлөвлөгөөтэй адил урт хугацааны хөрөнгө оруулагчдын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд ирээдүйд олгогдох хувьцааны нэгжийн тоо ширхэг хугацааг ТУЗ тодорхойлох бөгөөд дээрх эрхийг нөхөн төлбөр, урамшуулал болгох эсэхийг мөн тодорхойлно. Олгосон өдрөөс ирээдүйд олгогдох хувьцааны эрхийг шууд хэрэгжүүлэх боломжтой. Хугацаа дуусгавар болох, эсвэл хөтөлбөрт хамрагдсан гишүүн нас барсан тохиолдолд Компани тухайн гишүүний хувийг бэлэн мөнгөөр эсвэл үнэт цаасаар зах зээлийн үнэлгээгээр худалдан авах боломжтой. Энэ нь Компанийн сонголтоор хийгдэх бөгөөд Компани бэлэн мөнгөөр худалдан авахгүйгээр шийдвэрлэвэл энэхүү төлөвлөгөө нь үнэт цаасанд суурилсан хөтөлбөрт шилжинэ.

2020 оны 6 сарын 30-ны байдлаар эцэс болсон 6 сарын хугацаанд, Компани нэгж тус бүрийг \$0.24 кан.доллараар үнэлсэн 549,127 ширхэг ирээдүйд олгогдох хувьцааны эрх олгосон (2019 - \$0.20 кан.доллараар үнэлсэн 762,391 ширхэг олгосон). Бодит үнэлгээ нь \$129,438 кан.доллар (2019 – \$150,460) бүхий ирээдүйд олгогдох хувьцааны эрх нь Захиргаа, удирдлагын зардал болон хайгуулын зардалд тусгагдсан. 2020 оны 6 сарын 30-ны байдлаар эцэс болсон 6 сарын хугацаанд Эрдэнэ Ресурс нь ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн төлөвлөгөөнөөс нэгж бүр нь \$0.18 кан.долларын үнэлгээ бүхий 719,212 хувьцааг гаргасан (2019 - \$0.17 кан.доллараар үнэлсэн 175,069 олгосон).

	2020.06.30-нд дуусгавар болсон	2019.06.30-нд дуусгавар болсон
Олгогдсон өдрөөс тооцоолсон 5 өдрийн жигнэсэн дундаж үнэ	\$ 0.24	\$ 0.20

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй, нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулаагүй)

2019 болон 2020 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сар болон хагас жилийн тайлан

8. Хувьцаат капитал, нэмэлт хөрөнгө (үргэлжлэл)

2019, 2020 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон жилийн эцсийн байдлаар ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн тухай мэдээлэл:

	2020.06.30	2019.06.30
	Тоо ширхэг	Тоо ширхэг
1 сарын 1-ний байдлаар	4,636,850	3,954,118
Олгосон	549,127	762,391
Гаргасан	(719,212)	(175,069)
3 сарын 1-ний байдлаар	4,466,765	4,541,440

Варрант

Доорх хүснэгтэд 2019 болон 2020 оны 6 сарын 30-ны байдлаар варрантын мэдээллийг үзүүлэв:

	2020.06.30		2019.06.30	
	Варрантын тоо	Жигнэсэн дундаж хэрэгжих үнэ	Варрантын тоо	Жигнэсэн дундаж хэрэгжих үнэ
1 сарын 1-ний байдлаар	30,252,774	\$ 0.49	12,389,904	\$ 0.65
Гаргасан	-	-	11,284,614	0.40 - 0.50
Хэрэгжсэн	-	-	(1,075,324)	1.20
6 сарын 30-ны байдлаар гаргасан	30,252,774	\$ 0.49	22,599,194	\$ 0.53
6 сарын 30-ны байдлаар хэрэгжих боломжтой	30,252,774	\$ 0.49	22,599,194	\$ 0.53

2020 оны 6 сарын 30-ны байдлаар хэрэгжих боломжтой варрантын мэдээлэл:

Хэрэгжүүлэх үнэ	Варрантын тоо	Гэрээний жигнэсэн дундаж хугацаа (үлдсэн жил)
\$0.30	7,653,550	1.13
\$0.50	11,284,614	0.67
\$0.60	11,314,580	0.44
	30,252,744	0.70

Хувьцааны опцион

Компани тогтмол 10%-ийн опционы урамшууллын хөтөлбөр ("Хөтөлбөр") хэрэгжүүлдэг бөгөөд энэхүү хөтөлбөрийн хүрээнд Компанийн ТУЗ-ийн гишүүд, удирдлага, ажилтан албан тушаалтнууд компанийн хувьцааг худалдан авах опционыг худалдан авч, хэрэгжүүлэх боломжтой. Опционыг хэрэгжүүлэх, олгох нөхцөлүүдийг ТУЗ тодорхойлно. Опционыг олгохдоо нөхцөлийг өөрөөр заагаагүй бол олгосон өдрөөс эхлэн шууд хэрэгжүүлэх боломжтой. Төлөвлөгөөний хүрээнд энгийн хувьцааны хувьд олгох опцион нь Компанийн гаргасан болон зах зээлд энгийн хувьцааны 10%-аас хэтрэхгүй байх ба опционыг олгох шийдвэр гаргах үед нэг хүнд 5%-аас илүү олгох эрхгүй (хорогдуулахгүй байдалд үндэслэдэг).

2020 оны 6 сарын 30 байдлаар жигнэсэн дундаж хэрэгжүүлэх үнэ нь \$0.22 кан.доллар бүхий 550,000 опционыг олгосон. 2020 оны 6 сарын 25-нд 250,000 опционы хугацаа дууссан.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй, нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулсан)

2019 болон 2020 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сар болон хагас жилийн тайлан

8. Хувьцаат капитал, нэмэгдэл (үргэлжлэл)

2019, 2020 оны 6 сарын 30-ны байдлаар үнэт цаасны опционд гарсан өөрчлөлтүүд:

	2020.06.30		2019.06.30	
	Опционы тоо	Хэрэгжүүлэх боломжтой жигнэсэн дундаж үнэ	Опционы тоо	Хэрэгжүүлэх боломжтой жигнэсэн дундаж үнэ
1 сарын 1-ний байдлаар	12,305,000	\$ 0.41	11,335,000	\$ 0.43
Олгосон	550,000	0.22	2,520,000	0.20
Хугацаа дууссан	(250,000)	0.20	(230,000)	0.16
Хэрэгжүүлсэн	(1,150,000)	0.15	(1,105,000)	0.15
6 сарын 30-ны байдлаар	11,455,000	\$ 0.43	12,520,000	\$ 0.42
6 сарын 30-ны байдлаар хэрэгжих боломжтой	11,455,000	\$ 0.43	12,520,000	\$ 0.42

2020 оны 6 сарын 30-ны байдлаар хэрэгжих боломжтой опционы мэдээлэл:

Үнийн хүрээ	Хэрэгжүүлэх боломжтой опционы тоо	Гэрээний жигнэсэн дундаж хугацаа (үлдсэн жил)	Хэрэгжүүлэх боломжтой опционы жигнэсэн дундаж хэрэгжүүлэн үнэ
\$0.16 - \$0.24	3,900,000	3.34	\$ 0.19
\$0.25 - \$0.49	4,910,000	2.24	0.38
\$0.50 - \$0.89	2,645,000	1.78	0.86
	11,455,000	2.51	\$ 0.43

Хувьцаанд суурилсан нөхөн олговор

2020 оны 6 сарын 30-ны байдлаар Компани нь For \$197,687 кан.долларыг хувьцаанд суурилсан нөхөн төлбөрийн хэлбэрээр нэгтгэсэн алдагдалд зарлагадсан, үүнээс \$20,898 кан.долларыг хайгуулын зардалд тооцсон.

9. Хайгуул болон үнэлгээний зардал

2020 болон 2019 оны 6 сарын 30-ны байдлаар гурав болон зургаан сарын хугацааны хайгуул болон үнэлгээний зардлын мэдээллийг дор харуулав:

	6.30-нд дуусгавар болсон 3 сар		6.30-нд дуусгавар болсон 6 сар	
	2020	2019	2020	2019
Элэгдэл хорогдол	\$ 3,719	\$ 3,623	\$ 7,381	\$ 7,229
Шууд зардал	63,214	120,744	154,630	227,802
Ажилтан, албан тушаалтнуудын нөхөн олговор	50,722	32,269	128,332	94,778
Хувьцаанд суурилсан нөхөн олговор	16,391	89,400	20,898	93,777
	\$ 134,046	\$ 246,036	\$ 311,241	\$ 423,586

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй, нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулагдаагүй)

2019 болон 2020 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сар болон хагас жилийн тайлан

10. Захиргаа, удирдлагын зардал

2019 болон 2020 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон зургаан сарын захиргаа, удирдлагын зардлын мэдээллийг доор харуулав:

	6 сарын 30-нд дуусгавар болсон 3 сар		6 сарын 30-нд дуусгавар болсон 6 сар	
	2020	2019	2020	2019
Захиргааны үйлчилгээ	\$ 84,542	\$ 94,207	\$ 180,894	\$ 204,123
Элэгдэл, хорогдол	9,261	2,153	18,577	4,065
ТУЗ-ийн гишүүдийн төлбөр, зардал	-	37,091	44,583	65,009
Хөрөнгө оруулагчтай харилцах, маркетинг	25,440	23,093	86,399	55,316
Оффис, бусад	19,366	30,205	40,405	62,123
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	69,401	46,087	107,857	77,886
Зохицуулагч байгууллагын төлбөр, зардлууд	27,199	22,568	64,387	70,805
Хувьцаанд суурилсан нөхөн олговор	116,775	236,109	176,789	284,183
Томилолтын зардал	-	6,415	6,167	20,734
	\$ 351,984	\$ 497,928	\$ 726,058	\$ 844,244

11. Санхүүгийн хэрэгслүүд

Зээлийн эрсдэл:

Зээлийн эрсдэл нь санхүүгийн хөрөнгийн хамгийн өндөр эрсдлийг агуулдаг. Тайлагнах өдрөөр тасалбар болгон зээлийн эрсдэл нь хамгийн их өндөр байгаа нь:

	Бүртгэгдсэн дүн	
	6.30 2020	12.31 2019
Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах	\$ 1,915,353	\$ 5,106,863
Авлага	118,414	70,361
	\$ 2,033,767	\$ 5,177,224

Компани нь бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг Канад улсын тэргүүлэгч санхүүгийн байгууллагуудад байршуулж, зээлийн эрсдэлийг удирддаг. 2020 оны 6 сарын 30-нд бэлэн мөнгөний үлдэгдлийн 10% буюу \$191,493 кан.долларыг Канад улсаас гадуурх банкуудад байршуулсан. (2019 оны 12 сарын 31 - \$60,511 буюу 1%).

Төлбөрийн чадварын эрсдэл:

Компанийн хөрвөх чадварын эрсдэл нь өр төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулах үүргээ биелүүлэхэд үүсэж болзошгүй хүндрэлтэй холбоотой эрсдэлийг хэлнэ. Компани нь энэхүү эрсдэлийг удирдлагын хүрээнд санхүүгийн хэвийн болон хүндрэлтэй аль ч нөхцөлд шаардлагагүй гарз хүлээхгүйн тулд санхүүгийн өр төлбөр төлөгдөх хугацаанд хангалттай хэмжээний нөөцтэй байх бодлого баримталдаг.

Зах зээлийн эрсдэл:

Зах зээлийн эрсдэл гэж үнэт цаасны ханш, таваарын зах зээл, валютын ханш, хүүгийн түвшин зэрэг зах зээлийн хүчин зүйлсээс шалтгаалан өөрчлөгдөх магадлалтай эрсдэлүүдийг хэлнэ.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй, нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулагдаагүй)

2019 болон 2020 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сар болон хагас жилийн тайлан

Зах зээлийн эрсдэл (үргэлжлэл)

а) Хүүгийн эрсдэл

2020 оны 6 сарын 30-ны байдлаар Компанийн хөрвөр нөхцөлтэй зээл нь 10%-ийн тогтмол хүү тооцогдох тул хүүгийн өөрчлөлтийн эрсдэлд өртөхгүй болно.

б) Гадаад валютын эрсдэл

Компанийн үйл ажиллагааны голлох валют нь Канад доллар бөгөөд охин компаниудын голлох валют нь Монгол төгрөг юм. Түүнээс гадна, Компани нь Америк доллараар санхүүжилт авч, зардлыг гаргасан. Иймээс Канад долларын бусад валюттай харьцах хэлбэлзэл нь санхүүгийн хөрөнгө, өр төлбөр болон үйл ажиллагааны үр дүнд нөлөөлөх боломжтой. Валютын хөрвөх эрсдэл бүхий санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдэд ам.доллараар илэрхийлэгдэх бэлэн мөнгө, өглөг, хуримтлагдсан өр төлбөр, Монгол төгрөгөөр илэрхийлэгдсэн бэлэн мөнгө, өглөг болон хуримтлагдсан өр төлбөр багтаж байна. Компани нь Канад улсын банкуудад канад болон ам.доллар байршуулдаг.

Мөн Компани нь хөрвөх нөхцөлтэй өр төлбөртэй холбоотойгоор ам.долларын валютын ханшийн эрсдэлд орох магадлалтай. Хугацаа дуусахад \$5 сая ам.долларын үндсэн төлбөр, капиталжуулсан хүүгийн төлбөр бүрэн төлөгдөж дуусна. Иймд, Компани нь Канад/Америк долларын ханшийн хэлбэлзэлтэй холбоотой эрсдэл үүсэх тул хөрвөх нөхцөлтэй өр төлбөрийг барагдуулахад илүү зардал гарах магадлалтай.

Компанийн гадаад валют (ам.доллар)-ын эрсдэлд өртөх байдлыг доор харуулав:

	6.30 2020	12.31 2019
Мөнгө болон түүнтэй адилтгах	\$ 1,759,962	\$ 4,854,316
Худалдаа, бусад авлага	-	-
Худалдаа, бусад төлөгдөх	(296,340)	(155,219)
Хөрвөх нөхцөлтэй зээл	(13,185,450)	(6,260,521)
	\$ (11,721,828)	\$ (1,561,424)

Ам.долларын ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь \$1,172,200 долларын цэвэр алдагдал дагуулах магадлалтай (2019 оны 12 сарын 31 - \$156,100).

Компанийн гадаад валют (төгрөг)-ын эрсдэлд өртөх байдлыг доор харуулав:

	6.30 2020	12.31 2019
Мөнгө болон түүнтэй адилтгах	\$ 2,833	\$ 7,963
Худалдаа, бусад авлага	7,992	5,877
Худалдаа, бусад төлөгдөх	(182,661)	(69,501)
	\$ (171,836)	\$ (55,661)

Монгол төгрөгийн ханшид орох 10%-ийн өөрчлөлт \$17,200 долларын цэвэр алдагдал дагуулах магадлалтай. (2019 оны 12 сарын 31 - \$5,600).

с) Үнийн эрсдэл

Компанийн санхүүгийн хэрэгслүүд нь эрдсийн хайгуул, олборлолтын салбарын таваарын үнийн хэлбэлзлээс бусад байдлаар үнийн шууд эрсдэлд орох магадлал багатай.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй, нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулагдаагүй)

2019 болон 2020 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сар болон хагас жилийн тайлан

11. Санхүүгийн хэрэгслүүд (үргэлжлэл)

Бодит үнэ цэн:

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан, тодруулгад тусгагдсан хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлоход бодит үнэ цэнийн ач холбогдлыг тусгасан шатлал ашигладаг. Үүнд:

- Түвшин 1: Идэвхтэй зах зээлд нэг төрлийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн өгөгдөл нь тогтоосон үнэтэй байна;
- Түвшин 2: Хөрөнгө болон өр төлбөрийн тогтоосон үнийн 1-р түвшинд багтсан үнээс бусад өгөгдөл шууд (жишээ нь үнэ) эсвэл шууд бус (жишээ нь үнээс гаралтай); ба
- Түвшин 3: Өгөгдөл нь хэмжиж болохуйц бус (зах зээлийн үйл ажиллагаа бага, эсвэл огт дэмждэггүй) байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд бодит үнэ цэнээр бүртгэсэн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийн шатлалыг санхүүгийн тайлангийн тодруулгад дараах байдлаар тусгасан. Үүнд:

	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3
Бодит үнэ цэнээр хэмжигдсэн хөрөнгө:						
Мөнгө болон түүнтэй адилтгах	\$ 1,915,353	\$ -	\$ -	\$ 5,106,863	\$ -	\$ -
Авлага	-	118,414	-	-	70,361	-
Хөрвөх нөхцөлтэй зээл	-	(7,564,732)	-	-	(1,927,151)	-

12. Холбогдох талууд

Компанийн голлох удирдлагын ажилтнуудад ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх албан тушаалтнууд багтдаг. Эдгээр голлох удирдлагын ажилтнуудын цалин урамшууллыг доор харуулав:

	6 сарын 30	
	2020	2019
ТУЗ-ийн гишүүдийн цалин	\$ 29,500	\$ 53,500
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	152,000	189,700
Ажилтнуудын цалин, урамшуулал	424,530	390,624
Голлох албан тушаалтнуудын хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	38,289	101,246
	\$ 644,319	\$ 735,070

13. Тайлант хугацаанаас хойш өрнөсөн үйл явдлууд

2020 оны 7 сарын 23-ны өдөр Эрдэнэ Ресурс нь нийт хаалттай санхүүжилтийн хүрээнд \$20 сая кан.долларын хөрөнгө оруулалт татан төвлөрүүлж байгаа бөгөөд ноён Эрик Спротт \$15 сая кан.долларын стратегийн хөрөнгө оруулалт хийсэн.

Дээрх санхүүжилтийн хүрээнд тус бүрийг \$0.45 кан.доллараар үнэлсэн 33,333,333 нэгж захиалгын баримт ("Subscription Receipts")-ыг ноён Эрик Спроттын эзэмшдэг хуулийн этгээд худалдан авч, түүнтэй зэрэгцэн тус бүрийг \$0.45 кан.доллараар үнэлсэн 11,111,111 ширхэг үнэт цаасны нэгжийг гаргасан. Захиалгын баримтууд нь үнэт цаасны нэгжид хөрвөх боломжтой бөгөөд үнэт цаасны нэгж бүр нь Компанийн нэг энгийн хувьцаа болон энгийн хувьцаа худалдан авах эрх болох нэг варрант ("Варрант")-

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй, нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулсан)

2019 болон 2020 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сар болон хагас жилийн тайлан

аас бүрдэнэ. Варрант бүр нь санхүүжилт хаагдсанаас хойш хоёр жилийн хугацаанд нэг энгийн хувьцааг \$0.60 кан.доллараар худалдан авах эрхийг олгоно

Орчуулга: Энэхүү тайлан нь Англи хэл дээр бэлтгэгдсэн албан тайлангийн орчуулга болно. Англи, Монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх мэдээлэл гарвал Англи хэл дээрх хувийг мөрдөнө.